

- эхэнд олгож байх, санхүүжилтын бусад эх үүсвэр олох эрх олгох,
- Хилийн болон шалган нэвтрүүлэх отряд, заставын зохион байгуулалтын бүтцийг нэг хэвшмэл шугаман бүтэцтэй бус цагийн байдлын ямарч нөхцөлд зохицуулан хувиргаж болохуйцаар тогтоох,
 - Хилийн Цэргийн байнгын бие бүрэлдэхүүнд тасралтгүй боловсрол, мэргэжил олгох, мэргэжил, мэргэшлийн түвшин дээшлүүлж байхаар албан ба албан бус боловсролын тогтолцооны боломжит хэлбэр, аргуудыг ашиглах,
 - Хилчдийн ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог бүх талаар хангах асуудлыг хилийн болон шалган нэвтрүүлэх харуул, ээлж, засталаас эхлэн шийдвэрлэх,
 - Улсын хил хамгаалалтад төрийн болон төрийн бус байгууллага, нэгж, иргэдийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг өндөржүүлэх,
 - Улсын хил хамгаалалтын хяналтын тогтолцоог жинхэнэ ёсоор бүрдүүлэх зэрэг болно.

*

*

*

Доктор /PhD/, дэд профессор Г.Дагважамц

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ӨӨРЧЛӨЛТӨД ЦЭРЭГ-УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Улсын хил хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоход зайлшгүй нөлөөлдөг хүчин зүйлийн нэг нь цэрэг-улс төрийн нөхцөл байдал юм.

Тэгвэл өнөөдөр цэрэг-улс төрийн байдал чухам ямар байна вэ? Өнөөдөр ертөнц хоёр туйлт хуваагдалгүй болов. Улс орнууд тэдгээрийн дотроос манай хөрш хоёр орны гадаад бодлого, цэрэг-стратегийн салбарт баримтлах үзэл баримтлал өөрчлөгдлөө.

Аль аль нь олон тулгуурт бие даасан гадаад бодлого явуулж дайны аюулыг сэрэмжлэн зайлуулах, зэвсэгт хүч, зэвсэглэлийг хорогдуулах, батлан хамгаалах зорилго нь зөвхөн өөрийгөө хамгаалахад чиглэгдэх болсон.

Гэлээ ч гэсэн энэ байдлыг шинэ хуучин хоёр зууны зааг дээрээс цэгнэж үзвэл нийгмийн санаа бодол алив мөргөлдөөнийг хүчээр шийдвэрлэх гэсэн хуучинсаг үзэл давтагдав.

Хүн төрөлхтний түүхэнд хамгийн их дайнч, цус асгаруулсан зуун бол XX зуун болов. Энэ зуунд дайн зэвсэгт мөргөлдөөний давтамж

тасралтгүй өссөөр ирсэн. Сүүлийн арван жил бүр ч гаарсан. 90-ээд онд 90 орчим улсыг хамарсан 100 гаруй дайн болж 7-9 сая хүн амь насаа алджээ.

Ер нь улс орынхоо төлөө тулалдахад бэлэн байдаг сэтгэлгээ өөрчлөгдөв. Хүн амыг дайнд хамруулж, тэдний цус нулимсыг урсгаж, барьж босгосноо балгас, товрог болгож, цөлмөхөөс хүн төрөлхтөн залхсан.

Гэтэл Косовогийн болон Чечений шинэ дайнууд XX зуунд гарч болох мөргөлдөөний дүр төрхийг харууллаа. Чечений нэгдүгээр дайн /94 оны 12 сараас 96 оны 6 сар хүртэл/ Оросын нийгмийн дэмжлэгийг хүлээгээгүй. Тэд байлдааны ажиллагаа хэрэггүй, гол буруутан нь Кремлийн эрх баригчид гэж үзэв. 1995 оны 1 сард Чеченид арми оруулахыг хүн амын зөвхөн 23 хувь нь дэмжиж, 55 хувь нь эсэргүүцэж байсан. Энэ эсэргүүцэл жилийн дараа 1996 оны эхээр 80-90 хувьд хүрсэн байв.

Гэтэл 1999 оны 9 сард эхэлсэн Чечений дайн явуулсан арга, шинж чанар түүнд Оросын хийгээд Чечений өөрийн хүн амын хандах хандлага, иргэдээс армид өгсөн итгэл, хоёр талын энгийн хүн амын хохирол зэрэг урьдынхаас өөр байв.

1999 оны 9 сарын эхээр Чечений зэвсэгт бүлэг Дагестанд довтлоход оросуудын 75 хувь нь уг түрэмгийллийг эрс эсэргүүцэж салан тусгаарлагчдын эсрэг холбооны засаг, хүчний байгууллагын явуулах шийдэмгий ажиллагааг дэмжсэн. Эмгэнэлт үйл явлууд ч оросуудын хэд хэдэн хотуудад болсон дэлбэрэлтийг Чечений хэт даврагсад үйлдсэн гэж үзэж Оросын олон нийтийн санаа бодол Чечений эсрэг бөмбөгдөлт /НАТО-гийн Югославт хийсэн бөмбөгдөлтийн нэгэн адил/ хийх, хилийг хаах, салан тусгаарлах бүх бүлэглэлийг устгахад цэргийн хүч хэрэглэх гэсэн гурван төрлийн ажиллагааг дэмжих болов.

Косово болон Чечений дайн нь бүхэлдээ өнгөрсөн, одоо ирээдүйн олон янзын дайнд хандах хандлагын ертөнцийг үзэх үзэл, эрх зүй, сэтгэл зүй, ухамсар, шинжлэх ухааны байр суурийг тодорхойлж байна. Дайныг нааштай үнэлэх нь цуст хохирлыг багасгах, ард түмнийг цөлмөх, нүсэр зардал гаргахгүйгээр ялалтад хурдан хүрэх арга замыг сүвэгчлэхэд хүргэж байна.

Өнөөдөр дайн айл бүрд телевиз радиогийн нэвтрүүлгийн хэлбэрээр хүрч байна. Олон нийтийн санаа бодол нийгмийн нөлөө бүхий хүч мөний хувьд улс төрчдийн хамгийн илүүтэй анхаарах объект болсон. Өнөөдөр зарим судлаачид "дэлхийн 3 дугаар дайнд эхлээд багагүй хугацаа өнгөрлөө. Энэ нь аж үйлдвэрийн нийгэм-мэдээллийн дайн болоод байна" гэдэг дүгнэлт хийж байгаа юм.

Монголчууд бид ч энэ дайнд өртсөн.

Улсын хил хамгаалалтын тогтолцоонд нөлөөлөх хамгийн гол хүчин зүйл бол хил хамгаалалтад оролцож буй хүний хүчин зүйл юм. Өнөөдөр эх оронч, шилмэл боловсон хүчнээр хил хамгаалалт, хяналтын байгууллага бэлтгэгдсэн үү?

Мэдээллийн дайнд өртсөн хэсэг нь тэр дайнд нэрвэгдэн хордож зэрэмдэг болсон, өөрөөр хэлбэл ёс суртахуун-сэтгэл зүйн хувьд ялзран доройтсон, эх орноо орхих, ижил нөхдөө буудах хүртлээ зэрлэгшсэн байв. Мэдээллийн дайнд өртөх орон зайд амьдраагүй хэсэг нь нийгэм-улс төрийн бодит байдлын хувьд дэндүү атаршсан, оюуны соёлын их цөлжилтөд өртсөн, их Нацагдоржийн хуучин хүүгийн төрхөөр амьдрагсад залуучуудын шилмэл биш гологдмол хэсэг хилд алба хаах болов.

Тэднийг өндөр ухамсартай эх оронч болгохоор бидний зохиодог ажил онол, үзэл суртал, агуулгын хувьд хоцрогдсон "Сурталчилгаа, соёл мэдээллийн" гэгдэх шоовдор алба болсон.

Ийм ядмаг албаар мэдээллийн дайнд нэрвэгдсэн хүмүүсийг тууштай эх оронч, баатарлаг хилчин болгож хүмүүжүүлэх хөг нь өнгөрчээ. Ийм зогсонги, ядмаг алба, үйл ажиллагаа үеэ өнгөрөөсөн байна. Өнөөдөр сурталчилгаа, соёл мэдээллийн энэ ажил хилчдийг ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэлтэй болгон боловсруулж чадахгүй болсон байна. Дээр нь энэ албыг штабын алба, үйл ажиллагааны хавсарга болгож, төрийн хүмүүжлийн энэ чухал албыг удирдан зохион байгуулдаг байгууллагыг нь устгаж энэ чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг нь тарааж, бэлтгэн гаргадаг тэнхимийг нь татан буулгаж устгасан. Ингэснээр юу хожив. Юу хэмнэв. Оюуны ямар хөрөнгө оруулалт хийв. Эцсийн эцэст түүний үр дүн хүнээ алдаж үнээ барсан, хэнэггүй, эрдэмгүй, дуулгаваргүй, эх оронч бус хүмүүсийн бүхэл бүтэн армийг буй болголоо.

Энэ чанараараа хилийн цэрэгт боловсон хүчний бодлого алдагдаж, хүний нөөцийн залгамж халаа үгүй болж, хил хамгаалалтын мэргэжлийн тогтолцоо байхгүй болжээ. Нэн даруй энэ том алдааг эрүүл саруул ухаанаар засах хэрэгтэй байна.

Улсын хилийн хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоход улс төрийн нөхцөл байдал нөлөөлдөг гэж үзвэл энд бас нэг зүйлийг дурдалтай. Бид өнөөг хүртэл удирдлага, засаглал хоёрыг адил хэмээн ойлгож байгаагаас дарга хүн заавал мэдлэгтэй байдаг мэтээр баримжаалвал өөртөө л таалагдсан бүхнийгээ шат шатанд дарга болгодог практикт шилжив.

Ийм сонголтоор албан тушаал эзэлсэн дарга маань хамт

олон-массын хүсэн хүлээж буй зүйлийг өөрийн мэдлэгийн хэмжээ, үзэл бодолд захируулж, албаа гэхээсээ амбицаа бодож, амьдралаа бөөцийлөх, эд хөрөнгөнд шунах, ил далдуур хөрөнгөжих бэлжихийг урьдал болгож байгаа.

Мэдлэг мэдэл хоёр ялгаатай бөгөөд мэдлэг бол тухайн хүний насных нь бол харин мэдэл нь зуурдынх гэдгийг ухаарахгүй байгаагаас эрх мэдлийн төлөө үхэн хатан зүтгэдэг болжээ. Ялангуяа Хилийн Цэргийн офицерууд хил хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэгч гол орчин, хилийн албаны менежер, түүнийг зохион байгуулагч байх ёстой. Ийм менежерийн амин сүнс нь шинжлэх ухааны мэдлэг юм. Гэтэл өнөөдөр мэдлэгийг хүндлэх, мэдлэгээр үнэлэх явдал орхигдож, мэдлэгийн зүгт тэмүүлэгчдийг хоосон номчирхогчид гэж адлах явдал түгээмэл болсон. Ийнхүү мэдлэгийг ад үзсэнээс онол практикийн нэгдэл алдагдаж, ам ажил хоёр зөрж, тэр нь богино настай, сорилт даахгүй, олон арван бичиг цаас үржүүлэхэд хүрч байна. Мэдлэггүй хүн мэдлэгийг ад шоо үздэг жамтай учир тэрээр ухаангүй гүйцэтгэгч нараар өөрийгөө хүрээлүүлдэг. Үүнээс болж түүний удирдсан анги, салбар, албанд хүнд суртлын өвчин буглаж, өөрсдийгөө хамгаалах бүс бий болгож, ар өврийн хаалга, хов жив, авилгал, атаа жөтөөгөөр амьсгалж эхэлдэг.

Сүүлийн жилүүдэд хилийн цэрэгт хар зүтгэл, сохор практик голлох болсноос тархиа ажиллуулахаас тавхайгаа гялалзуулдагийг илүүтэй үзэх болжээ. Өнөөдөр газар, хэлтэс, хилийн ангиудын дарга, орлогч нараар томилогдогсдыг харж байхад үнэхээр хүнээ оллоо гэх юм тун ховор, үүний цаана нэг ангийнхан, нэг нутгийнхан, цэргийн он жавууд, цаашилбал гэр бүл, удам угсаа, урд хойдох, өгөө аваагаа харах өнгө аяс тасрахгүй байна. Өнөөдөр манай офицерууд оюуны өндөр чадавхитай бяраа зааж, идэвхитэй, уйгагүй ажиллахыг хүний нөөцийн менежмент шаардаж байна.

Шинэ зуунд ахуй амьдралын сайн нөхцөлөөр хангагдсан, удирдлагад шууд буюу дам оролцдог, байгаа орчиндоо тэргүүлэх байрлалыг ямагт эзэлдэг, амьдралын олон өнгө, хар цагааныг мэдэрч ялгадаг меритокритууд хилийн цэрэгт хэрэгтэй байна. Гагцхүү эдгээр меритократуудыг шилж сонгож, сургаж бэлтгэж, онож дэвшүүлэх явдал нь хил хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох бас нэг үндэс болж байна.

Улсын хил, түүний хамгаалалт нь шинжлэх ухааны түвшинд судлагдаж Монгол Улсын шинжлэх ухаанд өөрийн зохих байр суудлаа эзлээгүй байна. Манай улсын шинжлэх ухааны аль ч салбарт улсын хил, түүний хамгаалалт хил орчмын нийгэм-эдийн засгийн хөгжлийн

талаар дорвитой судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй байгаа нь хязгаар нутгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд Монгол Улсын хилийн суурь судалгааг өөрийн орны болон гадаадын эрдэмтэн судлаачид, хил судлалын байгууллагын туслалцаатай хийж дэлхий нийтэд батагаажуулах шаардлагатай байна. Монголын түүхэн хил, түүхэн газар зүйн талаар Германы монголч эрдэмтэн Вальтер Хайсег 2 боть альбом, Английн монголч эрдэмтэн Ален Сандрес нэг боть зохиол, Норвегийн монголч эрдэмтэн, Татар болон Орос, Хятад, Японы судлаачид эрдэм шинжилгээний олон өгүүлэл бичиж нийтлүүлсэн нь Монголын хилийг ойлгох суурь үзлийг дэлхий нийтэд буй болгов.

Улсын хил хамгаалалт, хил болон хязгаар нутгийн цаг уур, эрдсийн баялаг, ашигт малтмал, нийгэм, эдийн засгийн байдлыг улсын хэмжээнд уг чиглэлээр суурь судалгаа хийдэг эрдэм шинжилгээ судалгааны байгууллагуудын хүч туслалцаанд тулгуурлан судалж, хил судлалын практикт нэвтрүүлэх нь чухал болов.

Иймд Монголын Хил Судлалын Үндэсний Нийгэмлэгийн үйл ажиллагааг судалгаа шинжилгээ, сургалт арга зүй, сурталчилгааны чиглэлээр улам идэвхижүүлж явуулах шаардлагатай байна.

*

*

*

*ХЦДС-ийн багш,
магистр Н.Дэмчиг*

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦООНД ОРОН НУТГИЙН ЗАСАГ ЗАХИРГАА, ХҮЧНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРД

Монгол Улсын Үндсэн хуулийн 4-р зүйлд "Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна. Монгол Улсын хилийг хуулиар тогтооно" гэж заасан нь улсын хилийн тухай асуудлыг үндэсний язгуур ашиг сонирхол - үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг гэж хууль ёсоор тунхаглаж байгаа хэрэг юм. Мөн хуулинд Монгол Улсын төр засаг, иргэдээс эх орныхоо үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлын салшгүй хэсэг, улсын хилийн хамгаалалтын талаар хүлээх үүргийг хуульчлан тогтоосон хэд хэдэн заалт бий. Монгол Улсын Хилийн тухай хуулинд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжийн улсын хилийн хамгаалалтад оролцох оролцоо, гүйцэтгэх үүрэг,